2020 оны 11 сарын 20-ны өдөр Дугаар А/1250 Улаанбаатар хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт
шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.17, 37 дугаар зүйлийн 37.2.8, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний хүрээнд иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж хөдөлгөөний зураглалыг үнэн зөв гаргах үүднээс иргэний цахим үнэмлэхний QR кодыг ашиглан иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх системийг хэрэглээнд нэвтрүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т даалгасугай.

2.Нийслэлийн гудамж, талбайд зорчиж байгаа иргэд болон төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг систем ашиглан бүртгэлжүүлж, нууцлалыг хадгалж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/-т, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Ихбаяр/-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР